



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 4/23

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 84 дүгээр сургуулийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 193,120,365.20 (нэг зуун ерэн гурван сая нэг зуун хорин мянга гурван зуун жаран таван төгрөг хорин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 84 дүгээр сургууль (С.Лхагвадулам)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 2 нэр төрлийн 173 ширхэг нийт 193,120,365.20 (нэг зуун ерэн гурван сая нэг зуун хорин мянга гурван зуун жаран таван төгрөг хорин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 5,190,000 (таван сая нэг зуун ерэн мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 1,557,000 (нэг сая таван зуун тавин долоон мянга) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Баянзүрх дүүргийн 84 дүгээр сургууль (С.Лхагвадулам)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (П.Магнайбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050000000

